



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1062  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох "Монголын либерал ардчилсан нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Дүгнэлтийн үндэслэл**

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

**Дүгнэлт**

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор "Монголын либерал ардчилсан нам"-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Монголын либерал ардчилсан нам"-ын мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙН  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan\_Bichig\2024\0420 GNAG-3.Docx

0001030685

Монголын Либерал Ардчилсан Намын  
2011 оны 11 дүгээр сарын 12-ний  
өдрийн Ятоот албан бичгийн хавсралт



### Монголын Либерал Ардчилсан Намын Мөрийн Хөтөлбөр

Өмнөтгөл – Бидний үзэл санаа

Нэг. Цар тахлын дараах Монгол Улс

Хоёр. Амьдрахад таатай Монгол улс


Гурав. Солонгорсон эдийн засаг

Дөрөв. Тэгш боломжийг хүн бүрт

Тав. Сэргээгдэх эрчим хүчийг дэмждэг Монгол улс


Зургаа. Аюулгүй байдлыг бэхжүүлэх нь

Долоо. Монголдоо үлдэж, сайхан амьдарцгаая




Өмнөтгөл – Бидний итгэл үнэмшил

- Бид Монгол хүний саруул ухаан, Монгол Улсын ирээдүйд итгэдэг.
- Бид хувь хүний эрх чөлөө, халдашгүй байдал, өмчтэй байх эрхийг хангаж, бие хүний хариуцлагыг нэмэгдүүлэх ёстой гэдэгт итгэдэг.
- Бид чөлөөтэй сэтгэх, шашин шүтэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд итгэдэг.
- Бид тэгш боломжид итгэдэг. Өөрийн боломжоо бүрэн дүүрэн ашиглаж чаддаг, хүмүүнлэг нийгмийг цогцлоох үүрэгтэй.
- Бид хүмүүний эрхэм чанарт итгэдэг. Шударга, хүмүүнлэг нийгэмд хүн бүр нэр төртэй амьдрах боломжтой гэдэгт итгэдэг.
- Бид нийгмийн эв нэгдэл, хөгжил цэцэглэлтийн үндсэн нэгж нь гэр бүл гэдэгт итгэдэг.
- Бид баялагийг бүтээх, өрсөлдөх чадварыг өсгөх үндсэн хүч нь хувийн хэвшил гэдэгт итгэдэг.
- Бид иргэний нийгмийн сайн дурын байгууллагууд, сайн дурын үйл хэрэг онцгой ач холбогдолтой гэдэгт итгэдэг.
- Бид парламентын ардчиллыг хүний эрх, эрх чөлөөг хамгийн сайн хангадаг гэдэгт итгэдэг.
- Бид эрх мэдэл хуваарилалт нь ардчиллын амин сүнс гэдэгт итгэдэг.
- Бид эрх мэдлийн төвлөрлийг сааруулах, нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлэх нь иргэдийн эрх ашгийг хамгийн сайн хамгаалдаг гэдэгт итгэдэг.
- Бид үндсэн хуульт төрийн тэргүүнийг үндэсний эв нэгдэл, тогтвортой байдлыг бэлгэддэг гэдэгт итгэдэг.
- Бид төр нь иргэдийнхээ өмнө үүргээ хамгийн сайн гүйцэтгэдэг, түргэн шуурхай, хүнд сурталгүй байх ёстой гэдэгт итгэдэг.
- Бид төр өөрийн ажлаа л хийж, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх ёстой гэдэгт итгэдэг.
- Бид хуулийн засаглал, шударга ёсонд итгэдэг. Хуулийн өмнө хүн бүр эрх тэгш байж, алагчлалгүй нийгмийг бүрдүүлэх ёстойд итгэдэг.
- Бид Монгол улсыг олон улсын тавцанд хүний эрхийг хамгаалахад идэвхтэй түүчээлэх ёстой гэдэгт итгэдэг.



- Бид Либерализмд итгэдэг. 21-р зууны хэрэгцээ шаардлага, ололт амжилт, сорилт бэрхшээлүүдтэй хамгийн нийцтэй улс төрийн үзэл санааг Либерализм гэдэгт итгэдэг.




A handwritten signature in black ink, consisting of several loops and strokes.



## Хоёр. Амьдрахад таатай Монгол улс

- 2.1 Гэр хорооллыг орон сууцжуулах, аятай таатай амьдралыг дэмжих үйл явцыг эрчимжүүлнэ.
- 2.1.1 Ипотекийн зээлийн үйл ажиллагааг хүртээмжтэй болгоно.
- 2.1.2 Гэр хорооллын дэд бүтцийг амжиргаандаа тохирсон аргаар аятай тухтай, утаагүй, бохирдолгүй амьдрах нөхцөл, боломжуудыг судалж шинээр олон шатлалын стандартыг нутагшуулна.
- 2.2 Хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.
- 2.2.1 Хүүхэд харах үйлчилгээ, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, залуу эцэг эхчүүдийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.
- 2.2.2 Хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх шинэлэг аргыг судлан нэвтрүүлж, цалин хөлсийн тогтвортой байдлыг хадгалах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.3 Ахмадуудын аятай таатай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
- 2.3.1 Нэрлэсэн тэтгэврийн тоо хэмжээг нэмэгдүүлэхэд бус, хуримтлуулсан тэтгэврийн сан дахь хөрөнгөө зохистой зарцуулан аятай таатай амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд анхаарна.
- 2.3.2 Ахмад насандаа идэвхтэй, эрүүл амьдрахад зориулсан хөтөлбөр санаачилж хэрэгжүүлнэ.
- 2.4 Залуучуудын хөгжлийг дэмжинэ.
- 2.4.1 Боловсролын зээл тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлж, шаардлага хангасан бол алагчлалгүй олгодог болгох нөхцлийг бүрдүүлнэ.
- 2.4.2 Залуучуудын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, сэтгэл зүйн үйлчилгээг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.





## Гурав. Солонгорсон эдийн засгийг хөгжүүлэх

- 3.1 Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 3.1.1 Нийтийн тээвэр, эрчим хүч, ундны ус, дижитал дэд бүтэц зэрэг иргэдийн нийтлэг эрх ашигт нийцсэн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлнэ.
- 3.1.2 Үер, зуд зэрэг байгалийн гамшгийг даван туулах, учирсан хохирлыг нөхөн сэргээхэд зориулагдсан дэд бүтцийг хөгжүүлнэ.
- 3.2 Сэргээгдэх эрчим хүчний технологийг дэмжинэ.
- 3.2.1 Нарны, салхины, усан цахилгаан станцуудын төслүүдийг эрчимжүүлж, олон улсын хөрөнгө оруулалтуудыг нэмэгдүүлнэ.
- 3.2.2 Сэргээгдэх эрчим хүчний судалгаа болон уг салбарт өрсөлдөх үндэсний бизнес эрхлэгчдийг дэмжинэ.
- 3.3 Жижиг бизнес эрхлэгчид болон энтрпренеруудыг дэмжих эко систем бүрдүүлнэ.
- 3.3.1 Шинээр бизнес эрхлэгчдэд зориулсан салбар тус бүрийн чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулж, төрийн байгууллагаас шинээр үйл ажиллгааг эхлүүлэхэд шаардагдах шат дамжлагыг хялбаршуулж ажиллана.
- 3.3.2 Уул уурхайн салбараас гадна бусад салбарын эдийн засагт оруулах үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- 3.3.3 Төрийн хүнд суртлыг бууруулж, бизнес эрхлэгчдэд ирэх төрөл бүрийн дарамтыг бууруулна.
- 3.4 Хөдөлмөрийн зах зээлийн хөгжлийг бий болгоно.
- 3.4.1 Мэргэжлийн боловсролын хөтөлбөрүүдийг шинэ зууны технологи, эдийн засгийн нөхцөл байдалд тохируулж шинэчлэх ажлыг эхлүүлнэ.
- 3.4.2 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг ажил олгогчид, үйлдвэрлэгчид, шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, боловсролын шинэчлэлд саналуудыг тусгаж ажиллана.
- 3.5 Ил тод, хариуцлагатай төсвийн зарцуулалт
- 3.5.1 Урт хугацааны төсвийн тогтвортой байдлыг дэмжсэн төсвийн бодлого баримталж ажиллана.
- 3.5.2 Татварын бодлогыг шударга, зохистой, үр дүнтэй байлгахад анхаарч ажиллана.

## Дөрөв. Тэгш боломжийг хүн бүрт

4.1 Боловсролын тэгш боломжийг бүрдүүлнэ.

4.1.1 Улсын сургуулийн сургалтын чанарт анхаарч, чанартай боловсролыг хүүхэд бүрт олгох боломжийг бүрдүүлнэ.

4.1.2 Сургуулийн өмнөх боловсролын чанарыг сайжруулж, насан туршийн боловсролын суурь мэдлэг олгоход анхаарна.

4.1.3 Боловсролын зээл, тэтгэлэгт хөтөлбөрүүдийг дэмжих замаар өсөх ирээдүйтэй боловсон хүчнүүдийн боловсрол эзэмших боломжийг дэмжинэ.

4.2 Эдийн засгийн тэгш боломжийг бүрдүүлнэ.

4.2.1 Ажил олгогч, баялаг бүтээгчдийн нийгмийн хариуцлагын үзүүлэлтийг нэмэгдүүлэх богино хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.

4.2.2 Гарааны бизнес эрхлэгчдийн бий болгосон ажил, үйлчилгээтэй уялдуулсан хөгжүүлэлт, сургалтын тогтолцоог нутагшуулна.

4.3 Нийгмийн шударга ёсыг дэмжинэ.


4.3.1 Эрх нь зөрчигдсөн, маргинал бүлгүүдийн хүний эрхийг сэргээх, хамгаалах тогтолцоог дэмжиж ажиллана.

4.3.2 Хууль тогтоомжуудын хэрэгжилтэд үнэлгээ хийж, хүн нас, хүйс, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл зэргээсээ хамаарч эрх нь зөрчигдөхөөс сэргийлж, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэхэд анхаарч ажиллана.

4.4 Шүүхийн шинэчлэлийг хэрэгжүүлнэ.


4.4.1 Шүүгчийн хараат бусаар ажиллах орчныг бүрдүүлэхэд анхаарна.

4.4.2 Эрүүгийн хууль болон бусад хууль тогтоомжуудад шинжилгээ хийж, шүүхийн шударга ёсыг сахиулах үйл ажиллагааг сайжруулна.





## Тав. Сэргээгдэх эрчим хүчийг дэмждэг Монгол улс

- 5.1 Сэргээгдэх эрчим хүчний технологид оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлнэ.
- 5.1.1 Нарны эрчим хүчийг ашиглаж буй айл өрхүүдийн тоог нэмэгдүүлэх, нарны эрчим хүчний шинэ технологийг нэвтрүүлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 5.1.2 Говь цөл зэрэг нар, салхины нөөц бүхий бүс нутгуудыг түшиглэсэн сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн тоо хэмжээг нэмэгдүүлнэ.
- 5.1.3 Усан цахилгаан станцын төслүүдийн бүтээн байгуулалтыг хурдасгаж, шинэ төслүүдийг санаачлан хэрэгжүүлнэ.
- 5.2 Эрчим хүчний сүлжээний шинэчлэлийг эхлүүлж, эрчим хүч хадгалах технологийг нэвтрүүлнэ.
- 5.2.1 Эрчим хүчний сүлжээний шинэчлэлийг хийж, тогтвортой, аюулгүй, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлнэ.
- 5.2.2 Эрчим хүч хадгалах технологийг нэвтрүүлж, эрчим хүчний үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангана. 
- 5.2.3 Хөрш орнуудаас эрчим хүчээр хараат байдлыг бууруулж, бие даасан эрчим хүчний тогтолцоотой болох, цаашлаад эрчим хүч экспортлох суурь эхлэлийг тавина.
- 5.3 Эрчим хүчний үр ашигтай байдлыг нэмэгдүүлнэ.
- 5.3.1 Барилга байгууламж, үйлдвэрлэл, айл өрхүүдийн хэрэглээг эрчим хүчинд хэмнэлттэй, экологид ээлтэй байлгах стандарт боловсруулж, мөрдүүлэх ажлыг санаачилна.
- 5.3.2 Эрчим хүчний балансын судалгааг хийж, бодлогын тогтвортой байдлыг хангана.
- 5.3.3 Эрчим хүчний хэмнэлт, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах талаар иргэдийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.



## Зургаа. Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх нь

- 6.1 Үндэсний батлан хамгаалах салбарын шинэчлэлийг эхлүүлнэ.
- 6.1.1 Зэвсэгт хүчний техник хангамжийг орчин үеийн стандартад нийцүүлнэ.
- 6.1.2 Олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, энхийг сахиулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно.
- 6.1.3 Цахим аюулгүй байдлын стандартыг нэвтрүүлж, иргэдийн мэдээлэл, эдийн засаг, дэд бүтцийн салбарт хийгдэж буй дижитал шилжилтийн үйл явцад аюулгүй байдлыг хангахад анхаарч ажиллана.
- 6.2 Хилийн аюулгүй байдал, хилийн удирдлагыг сайжруулах нь
- 6.2.1 Хилээр хууль бусаар нэвтрэх, хүн худалдаалах, хориотой бараа бүтээгдэхүүн нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулж, эрсдэл бүхий хилийн боомтуудын хяналтыг сайжруулна.
- 6.2.2 Хилийн үйл ажиллагааны удирдлагыг сайжруулж, үр дүнтэй, оновчтой туршлагауудыг нэвтрүүлж, хилийн хамгаалалтын технологиудыг орчин үеийн стандартад нийцүүлнэ.
- 6.3 Төрроризмоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 6.3.1 Цагдаа, тагнуулын үйл ажиллагаа, ур чадварыг сайжруулах замаар төрроризмоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 6.3.2 Иргэдийн эв нэгдэл, хамтач байдлыг дэмжиж хүчирхийллийн бус замаар аливаа асуудлыг зөвшилцөж шийдвэрлэдэг байдлаа бататгана.
- 6.4 Хүрээлэн буй орчны аюулгүй байдал
- 6.4.1 Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, байгалийн гамшиг зэргийн эсрэг хэрэгжүүлж буй өнөөгийн бодлогуудад дүн шинжилгээ хийж, үр дүнг сайжруулна.
- 6.4.2 Уул уурхайн үйл ажиллагааг байгаль орчинд ээлтэй байлгахад анхаарч, нөхөн сэргээх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

## Долоо. Монголдоо үлдэж, сайхан амьдарцгаая

7.1 Дээд боловсролын шинэчлэлийг эхлүүлж, эх орондоо чанартай боловсрол эзэмших нөхцлийг бүрдүүлнэ.

7.1.1 Их дээд сургуулийн чанар, чансааг нэмэгдүүлэх үүднээс боловсролын шалгуур үзүүлэлтийг сайжруулах, гадаад хамтын ажиллагааг дэмжиж Монголдоо чанартай дээд боловсрол эзэмшдэг байх нөхцлийг бүрдүүлнэ.

7.1.2 Шинжлэх ухааны тэргүүлэх зорилт бүхий төслүүдийг олон улсын байгууллага, хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд хурдтай хөгжүүлэх төвүүдийг байгуулна.

7.2 Эх орондоо ажиллах, мэргэжлийн ур чадвараа хөгжүүлдэг байх нөхцлийг бүрдүүлнэ.

7.2.1 Технологи, сэргээгдэх эрчим хүч зэрэг нарийн мэргэжлийн үйлдвэрлэлүүдийг дэмжих замаар, чадварлаг боловсон хүчнүүдээ эх орондоо ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

7.2.2 Мэргэжлийн сургалтын чанарыг сайжруулж, хөдөлмөрийн зах зээлийн импорт, экспортын харьцааг Монголчууддаа ээлтэй байлгахад анхаарч ажиллана.

7.3 Амьдралын чанарыг сайжруулах, аятай таатай амьдрах орчныг сайжруулна.

7.3.1 Төрийн үйлчилгээг чанартай хүртээмжтэй, хүнд сурталгүй болгох үйл явцыг хурдасгана.

7.3.2 Ажил, хувийн амьдралын тэнцвэрийг хангахад анхаарч, уян хатан ажлын цаг, гэр бүлд ээлтэй амьдралын хэв маягийг бий болгоход төрийн бодлогыг чиглүүлнэ.